



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
**ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБАНЫ  
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 03 сарын 30 өдөр

Дугаар А/с1

Сүмбэр сум

Эргэлтийн хөрөнгө актлах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.6 дах заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, 31.3.1 дэх хэсэг, байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэрийг тус тус үндэслэн Тушаах нь:

1. Байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэрээр актлагдсан 2,073,601 /хоёр сая далан гурван мянга зургаан зуун нэг/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий 12 нэр төрлийн эргэлтийн бус хөрөнгийг акталж, байгууллагын данс бүртгэлээс хасалт хийхийг нягтлан бодогч цагдаагийн ахлах дэслэгч \Ж.Ууганцэцэгт/-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус 12 нэр төрлийн 2,073,601 /хоёр сая далан гурван мянга зургаан зуун нэг/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгах ажлуудыг цагдаагийн ахмад /З.Эрдэнэбат/-д даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг цагдаагийн хошууч /Л.Жаргалтогтох/-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалыг нийт бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулсугай.

ДАРГА,

ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА

Б.ТӨРБАТ





ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
**ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБАНЫ  
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 1102.

Сүмбэр сум

Хагас жилийн үндсэн ба эргэлтийн  
хөрөнгийн тооллого хийх тухай

Нягтлан бодох бүртгэлийн, тухай хуулийн 12-р зүйлийн 12.1, 12.2.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1, Хууль зүй дотоод хэргийн сайдын 2011 оны 82 дугаар тушаалаар батлагдсан "Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн дүрэм"-ийн 5.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн Тушаах нь:

1. Байгууллагын хагас жилийн эд хөрөнгийн тооллогыг 2022 оны 05 дугаар сарын 9-ний өдрөөс 05 дугаар сарын 13-ны өдрийг хүртэл явуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Ж.Ууганцэцэг                      нягтлан бодогч, цагдаагийн ахлах дэслэгч

Гишүүд:

Э.Билгүүн                              Шинжээч, цагдаагийн дэслэгч

У.Батбаяр                              Туслах ажилтан, цагдаагийн дэд ахлагч

2. Эд хөрөнгийг нэг бүрчлэн чанартай тоолж ажиллахыг ажлын хэсэгт, хяналт тавьж, дүнг нэгтгэн илтгэх хуудсаар танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч цагдаагийн ахлах дэслэгч /Ж.Ууганцэцэг /-д тус тус үүрэг болгосугай.

3 Энэхүү тушаалыг нийт бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулсугай.

ДАРГА,

ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА

Б.ТӨРБАТ

